

Я. Н. Засурскый

СЭТГҮҮЛЧДИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, БИЕ ДААСАН БАЙДАЛ: ӨӨРИЙН ЦЕНЗУР, ӨӨРИЙН ХЯНАЛТ

Өнөөдөр сэтгүүлчдийн эрх чөлөө, бие даасан бадйлын тухай асуудал нэлээд хурцаар тавигдах болов. Хамгийн санаанд оромгүй байгууллагууд хүртэл энэ асуудлыг эрхэлж байна. Хачирхалтай нь гэвэл энэ талаар сүүлийн үед хэвлэлд гарсан зүйлүүдийг сэтгүүлчид бус, төрийн эрх барих байгууллагууд санаачилсан аж. Энэ сэдвээр Ерөнхийлөгчийн зарлиг, Дээд Зөвлөлийн тогтоол хэд хэдэн удаа гарав. Бүгд л хэвлэлийн эрх чөлөөний талаар санаа тавьснаас улбаатай. Хэрэв та үүнийг хэн батлан гаргасныг нь дурдалгүй уншиж, иш татах аваас хуулийг зохиогч, санаачлагч нь хэн болохыг шуудхан хэлчихэж чадахгүй биз. Яагаад гэвэл эдгээр зарлиг, тогтоолуудын аль аль нь хэвлэлийн эрх чөлөөг дээдлэх учир шаардлагыг оршил хэсэгтээ дурджээ. Гэхдээ зарим нэгэн ялгаатай зүйл бий. Жишээ нь, "Мэдээллийн тогтвортой байдлыг баталгаажуулах, радио, телевизийн нэвтрүүлэгт тавих шаардлагын тухай" Ерөнхийлөгчийн зарлигт мэдээллийн тогтвортой байдал гэдэг шинэ ойлголт гарч иржээ. Мэдээллийн тогтвортой байдал гэгч юу вэ? Энэ тогтвортой байдал нь хэвлэлийн ямаршуу эрх чөлөө, хараат бус байдал, үйл ажиллагааг хэлнэ вэ? Мэдээллийн хамгийн тогтвортой байдал манай оронд тодорхой цаг үед байсныг бид мэднэ. Загвар жишгийн хэмжээний илүү тогтвортой байдал буй болгох боломжгүй мэт санагдана.

Энэхүү зарлигт цааш нь эдийн засаг, мэдээллийн өөрчлөлт шинэчлэлийн нөхцөлд мэдээллийн тогтвортой байдлыг сахин хамгаалах үүднээс мэдээллийн хариуцлагатай бодлогоор хангах шаардлагатай гэжээ. Мэдээллийн хариуцлагатай бодлого гэж юуг хэлнэ вэ? Мэдээллийн хариуцлагатай бодлогын талаар Италийн нэрт сэтгүүлч, улс төр судлаач Бенито Муссолини зохиол бүтээлүүддээ хамгийн дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг. Тэрбээр мэдээллийн хариуцлагатай бодлогын талыг хамгийн ихээр баримтлагч бөгөөд түүний онолын үзэл баримтлалын гол цөм нь хариуцлагатай байх зарчим байлаа.

Ерөнхийлөгчийн зарлигт зарчмын хувьд сонирхолтой зүйл нэлээд байвч ойлгомжгүй зүйл ч мөн байгааг хэлэх учиртай. Түүний баталсан "Радио, телевизийн нэвтрүүлэгт тавих шаардлагын наад захын жишиг"-т нэвтрүүлгийн нэг сувгийн хүрээнд албагүй ч бүс нутгийн, үндэсний болон бусад сонирхлын үүднээс сонирхсон хөтөлбөрөө (нэвтрүүлгээ) сонгох боломжийг телевиз үзэгчдэд олгох" гэсэн журмын заалт оржээ. Үүнээс үзвэл нэг суваг нь бүс нутгийн, үндэсний болон бусад сонирхлын үүднээс нэвтрүүлгийн хөтөлбөрөө сонгохгүйгээр байж бас болох нь ээ. Мөн тэнд радио, телевизийн нэвтрүүлгийн... бүрэн бүтэн байдлыг хамгаалах, нэвтрүүлгийн дундуур зар

сурталчилгаа явуулахгүй байх тухай оржээ. Намайг өчигдөрхөн телевиз үзэж суухад кино болгоны дундуур тасалж зар сурталчилгаа оруулж байлаа. Түүнээс гадна доод хэсэгт нь зар сурталчилгааны мөрүүд бичигдсэн кино гарах болов. Иймэрхүү зүйл дэлхийн практикт өнөөг хүртэл байдаггүй биз дээ.

Энэ мэтээр зарлиг, тогтоол дарлаа ч юутай ч гэсэн тэр нь амьдралд биелэл болохгүй байна... Энэхүү "наад захын жишиг"-т мэргэжлийн хариуцлагын тухай бидэнд шууд хамаарах 5 дугаар зүйл бий. Энэ зүйлд "Сэтгүүлчийн өөрийн хяналт, бэлтгэн тарааж буй мэдээ материалынхаа төлөө хүлээх хариуцлагыг мэргэжлийн зайлшгүй шаардлага хэмээн үзэх"-ээр заажээ.

Энд өөрийн хяналт, бэлтгэн тарааж буй мэдээний талаарх хариуцлагын тухай ойлголтыг дэвшүүлсэн байна. Гэхдээ "өөрийн хяналт" гэж юу болох тухай заасангүй. Ийм болохоор сэтгүүлч хүний эрх чөлөө бие даасан байдал, өөрийн хяналт, өөрийн цензурын тухай асуудлаар ярилцахыг хүсч байна. Учир нь бэлтгэн тарааж буй мэдээ материалынхаа төлөө сэтгүүлч хүний хүлээх хариуцлагын тухай ярихад хүрвэл үүнийг зөвхөн өөрийн хяналтын талаас нь төдийгүй, өөрийн цензурийн талаас нь авч ойлгох хэрэгтэй болно. Сэтгүүлч хүн эфирт нэвтрэхгүй нь лавтай гэсэн зүйлээ авч хаядаг. Тэгэхээр өөрийн цензур, хариуцлага хоёрыг хэрхэн зааглах вэ?

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хуулиа бид зохих ёсоор нь үнэлэх хэрэгтэй. Энэхүү хууль сэтгүүлч бидэнд тодорхой эрх чөлөө эдэлж, хараат бус байх боломж олгож байгаа юм. "Сэтгүүлчийн эрх" гэсэн 47 дугаар зүйлийн 10-т "өөрийн итгэл үнэмшилд нийцээгүй мэдээ материалыг өөрийн нэрээр бэлтгэхээс татгалзах" эрхийг сэтгүүлчдэд олгожээ. Уг зүйлийн 11-д "Энэхүү хуулийн 42 дугаар зүйлийн нэгдүгээр хэсэгт заасны дагуу сэтгүүлч өөрийн бэлтгэсэн мэдээ материалын утга агуулга нь хянан найруулах явцад гажуудсан гэж үзвэл гарын үсгээ буцаах, эсхүл нийтлэхийг хориглох буюу өөр байдлаар уг материалыг ашиглах нөхцөлийг тусгайлан заах эрхтэй" гэжээ. Миний бодлоор энд сэтгүүлчдэд бие даан чөлөөтэй ажиллах боломж нээгдэж байна. Сэтгүүлч хүн удирдлагынхаа шаардлагыг биелүүлэхгүй байж болох ба энэ утгаараа өөрийн цензур буюу өөрөө засварлан нийцүүлэх явдлаас зайлсхийх боломжтой болно.

Өөрийн цензур, өөрийн хяналт гэсэн энэ хоёр ойлголтыг ер нь хэрхэн зааглах вэ? Ихэнх хүмүүс өөрийн цензур, өөрийн хяналт гэдгийг нэг мөр ойлгодог. Эльдар Рязанов, Владислав Листьев хоёрын саяхны нэгэн теле маргаан ч мөн тийм байв. Рязанов, Лисьев хоёулаа өөрийн хяналтыг өөрийн цензур мөн гэгцгээж байлаа. Ямар нэгэн ёс зүйн хүрээнээс хальж үл болох хэр хэмжээ, хариуцлагаа ухамсарлах тухай тэд ярьцгаасан юм. Гэвч энэ тохиолдолд миний бодлоор энэ нь өөрийн цензур биш өөрийн хяналт юм. Өөрийн хяналт, өөрийн цензур гэдэг бол өөрийгөө хязгаарлах хоёр ондоо ангилал юм. Өөрийн цензур гэдгийг тодорхой заавар шийдвэрийг биелүүлэхийг шаардаж буй тодорхойхүчний шахалт дарамтаар хийж буй өөрийн хязгаарлалт

гэж би ойлгодог. Энэхүү заавар шийдвэрийг хэвлэл бэлэн болж гарах үед хэрэгжүүлж байдаг. Энэ тохиолдолд сэтгүүлч ямар нэгэн ээдрээтэй асуудлын талаар бичдэггүй, ямар нэгэн санал онол хэлдэггүй, тийм бодит боломж ч байдаггүй билээ. Яагаад гэвэл тэрээр хэвлэлийнхэн, эсхүл Засгийн газар, бусад ямар нэгэн байгууллага, жишээлбэл Хэвлэл, утга зохиолыг хянах газар (одоо түүнийг хэвлэлийн эрх чөлөөг хянах газар гэж нэрлэх болсон)-т үл таашаагдах хэсгийг урьдаас хасч залруулдаг билээ. Үүнийг л өөрийн цензур гэмээр санагдана. Хэвлэл, утга зохиолыг хянах газрын үйл ажиллагаатай холбоотой зохих хууль тогтоомж байхгүй байх нөхцөлд өөрийн цензур манай сэтгүүлчдийн үйл ажиллагааны чухал хэсэг байлаа. Сэтгүүлчид өөр өөрсдийгөө хязгаарлаж, эсхүл энэ үеийг далд утгатай ёгт хэллэг, бусад өөр хэлбэрээр аргацаахыг хичээдэг байв.

Өөрийн хяналтын тухайд гэвэл энэ нь сэтгүүлч хүн ёс зүйн тодорхой хэм хэмжээг баримтлан ямар нэгэн хэмжээгээр өөрийгөө сайн дураар хязгаарлаж байдгаараа өөрийн цензурээс ялгаатай бус харин ёс зүйн тодорхой жаяг, сэтгүүлчийн ёс суртахууныг дагаж хариуцлагаа ухамсарлах явдал юм. Энэ нь, жишээлбэл, бусдын хувийн амьдралд оролцох зэрэгтээ сэтгүүлч хүн, магадгүй, хуулийн дагуу ямар нэг мэдээлэл хийх эрхтэй боловч ёс зүйн тодорхой хэм хэмжээнд үл нийцэж байвал өөрийгөө хязгаарлаж байгаа үеийг хэлж байгаа юм. (Гэхдээ хэвлэлийн тухай хууль итгэл үнэмшилдээ нийцээгүй материалыг буцаахыг сэтгүүлчдэд зөвлөж, ингэснээр өөрийн цензур хийх шаардлагагүй гэсэн санаа өгч байна.)

Сэтгүүлч хүний өөрийн хяналтыг зохион байгуулах, хувийн сахилга батыг хангах олон хэлбэр бий. Сэтгүүлч хүнд хувийн сахилга бат байх ёстойг аль ч улс орны туршлага нотлон харуулж байгаа билээ. Англи улсад гэхэд өнөөдөр хатан хааны гэр бүлийн хувийн амьдралтай холбоотой олон шуугиант материал сонин хэвлэлд гарч байна. Ингэх нь хуулиар хориглоогүй хэдий ч нарийн ширийн нягталж үзвэл хууль тогтоомжид нийцэхгүй ч байж магадгүй.

Олонх улс оронд баримталдаг ёс зүйн хэм хэмжээний систем байдаг бөгөөд үүгээр сэтгүүлч хүний "тоглолтын дүрэм", үйл ажилдаа мөрдөх ёс зүйн хэм хэмжээ, тодорхойлогдож байдаг. Швед улсад л гэхэд омбудсмен гэдэг тусгай албан тушаал байдаг. Энэ хүн сэтгүүлчдийн үйл ажиллагааны талаарх гомдол саналыг хүлээн авч, дараа нь уг сэтгүүлчийн хамт олонтой хамтдаа хэлэлцэн шийдвэрлэдэг. Хэвлэл, телевизэд гоморхсон хэн боловч шүүхэд өгөхөөсөө өмнө омбудсменд хандах ёстой. Хэрэв тэр омбудсмен өөрийн түвшинд асуудлыг шийдвэрлэвэл цааш нь авч хэлэлцдэггүй. Ийм замаар нөхцөл байдлыг эрүүлжүүлэх ёс зүйн тодорхой хэм хэмжээг сэтгүүлчдэд бүрдүүлдэг байна.

Өөрийн хяналт гэдэг ойлголтод юу багтах вэ? Юуны өмнө хэний ч талыг үл баримтлах шударга байдал, бодит хандлага орно. Дашрамд хэлэхэд ардын депутатуудын хурлын бүх л хууль, тогтоолуудад улс оронд өрнөж байгаа үйл

явдлыг улсын радио, телевизээр бодит байдлаар нь мэдээлж байх шаардлагатай гэж заасан билээ. Ерөнхийлөгчийн зарлигт ч энэ тухай бий. Бодитой байдлаар хандах тухай хэн хүнгүй л ярих боловч чухам сэтгүүлч хүн л хэрвээ чармайвал энэ бодит хандлагыг ажил хэрэг болгож чадна. Манай сэтгүүл зүйн уламжлал бодит хандлагын зарчимтай зөрчилдөж байдаг болохоор энэ нь бидэнд бүр ч чухал байгаа юм. Бидний уламжлал бол дайсантайгаа хайр найргүй тэмцэх, харш үзэл бодол, хөрөнгөтний үзэл суртлын эсрэг эвлэршгүй бат зогсох уламжлал билээ. Энэ уламжлал маань манай сэтгүүл зүйд ч үлдэж хоцорчээ. Манай сэтгүүл зүй эвлэршгүй хэвээр байна. Өнөөдөр улс төржин туйлширч байгаа манай сэтгүүл зүйн үйл ажиллагаанаас үүний жишээ олныг харж болно. Сонин хэвлэлд хэвлэлийн байгууллага бүр өөр өөрсдийн үзэл бодлыг илэрхийлж болдог ч телевизэд байдал арай түвэгтэй юм. Одоо манайд гарч байгаа олон сонин бүгд өөрсдийн "бодит хандлагыг" илэрхийлж байна. Би саяхан "Российская газета" сонины талаар "Московский комсомолец" сонин юу бичсэнийг уншиж үзэв. Энэ нь бараг л хана туурга, хашаан дээр эрээчсэн байдагтай адил зүйл байлаа. Мэдээжийн хэрэг энд ямар ч өөрийн хяналт алга. XVIII зууны Англи улсад "Нохой нохойгоо ноцдоггүй, сонин сониноо давшилддаггүй." Гэсэн хоёр хэсэгтэй хэвлэлийн тухай нэгэн хууль гарсныг санаж байна. Өнөөгийн манай нөхцөлд энэ зүйл мөрдөгдөхгүй байгаа юм.

Тэгсэн ч гэсэн бид сэтгүүл зүйн үл ялгаварлах шударга байдал, бодит хандлагад хэрхэн хүрэх вэ? Үүний тулд юуны өмнө ёс зүйн хэм хэмжээг тодорхойлох шаардлагатай байна. Үүнд манай үйлчилж байгаа Хэвлэл мэдээллийн хуулийн тухай хууль тодорхой хязгаарлалт тавиад байгаа юм. Бид бие даасан сэтгүүл зүйн статусыг тогтоож чадаагүй, манай сэтгүүл зүйн практикт өөрийн цензур тодорхой хэмжээгээр байсаар байгаа ба өөрийн хяналт тун сул нь харамсалтай.

Үүнтэй уялдуулан бодоход өнөөдөр манай сэтгүүл зүйд өөрийн хяналтыг хэрэгжүүлэхийн тулд сэтгүүлчийн мэргэжлийн доторх холбоо харилцааны өөр тогтолцоо буй болгох хэрэгтэй юм шиг байна. Одоогоор сэтгүүлчдийн нэгдсэн холбоо ч үнэн хэрэгтээ алга байна шүү дээ. Сэтгүүлчдийн холбоо тарж бутарсан. Москвагийн сэтгүүлчдийн холбоо гэж бий. Тэр нь хэрвээ та Оросын сэтгүүлчдийн холбооны гишүүн бол сэтгүүлчдийн ордондоо ч бид таныг шагайлгахгүй. Яагаад гэвэл энэ ордон чинь бидэнд, Москвагийн сэтгүүлчдийн холбоонд харьяалагддаг юм шүү гэцгээж байна. Сонины редакторуудын нэгдэл холбоо ч гэж байх боломжгүй хэмээн ярьдаг сэтгүүлчид байдгийг би мэднэ. Тэд редакторууд бол өрсөлдөгчид учраас нэгдмэл ашиг сонирхол гэгч юм тэдэнд байхгүй гэцгээж байна. Үүний зэрэгцээ цаас, хэвлэлийн үнэ өртөг, татвар зэрэг сэтгүүлчдийн хувьд нийтлэг байдаг хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэхэд тэдний сэтгэл нийлсэн үйл ажиллагаа шаардагдаж байна.

Бүх улс оронд хэвлэгчид нэгдэж байна, редакторууд нэгдэж байна. Манайд болохоор сэтгүүлчдийн эв нэгдэл гэдэг ойлголт үгүй болж сэтгүүлч мэргэжил, сэтгүүлчдийн багийн доторх уур амьсгал хурцадмал төдийгүй энэхүү улс төрийн дотоод тэмцлийн явцад улам гажуудаж байна. Улс төрийн тэмцэл нь ёс зүйн зохих хэм хэмжээнээс давж, тэр ч бүү хэл энэ ёс зүйн хэм хэмжээ гэгч ер нь алга болжээ.

Өнөөдөр манай сэтгүүлчид өөрийн цензурт илүү өртөж байж магадгүй. Энэ талаар би ямар нэгэн ерөнхий дүгнэлт хийж чадахгүй. Гэхдээ нэгэн удаа Германы сэтгүүлчидтэй хийсэн уулзалт дээр манай “Сегодня” сонины нэгэн сэтгүүлчтэй ярилцсан юм. Сонинг эрхлэн гаргагчид “Независимая газета” сонины ерөнхий редактортой түнжин хагарснаас эл сониноос тасарч гарсныг та бүхэн мэднэ. Тэр сурвалжлагч надад: “Би юу бодсоноо өөрийнхөө сонинд нийтэлж чаддаггүй” гэсэн билээ. Өөрөөр хэлбэл тэр өөрийгөө бусдын хүсэл сонирхолд нийцүүлэн хянаж байдаг ажээ. Бусад сонин хэвлэл ч ялгаагүй түүний бодсон санасан бүхнийг хэвлэхийг зөвшөөрдөггүй тухай тэр ярьсан юм.

Миний бодлоор өнөөдөр манай хэвлэлд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн эздийн шахалт, зар сурталчилгааны дарамт дахин буй болж байна. Хэрвээ сэтгүүлчид мэргэжлийн ямар нэгэн нийтлэг тохиролцоонд хүрэхгүй бол, ийм хамгаалалтгүй бол энэ бүгдийг давж гарахад хэцүү юм. Төрийн зүгээс сэтгүүлчдэд хүчтэй дарамт үзүүлж байгаа нь маргаангүй. Ерөнхийлөгч, Дээд зөвлөл янз бүрийн хууль дүрэм батлан гаргаж байгаа нь ч гэсэн энэ дарамт шахалт, улс төржих байдлын илрэл юм. Хэдийгээр Ерөнхийлөгчийн зарлигт телевиз, радиогийн өрсөлдөх тогтолцоог буй болгох шаардлагатай тухай, өөр хаа нэгтэй янз бүрийн үзэл бодол, олон ургальч үзлийг төлөөлөх шаардлагатай тухай яригдаж байгаа боловч одоогоор манай сэтгүүл зүй олон дуу хоолойгоор бус ганц өнгөөр дуугарахад тэмүүлж байна. Энд хэвлэлийн эрх чөлөөнд санаа тавих бус, харин Ерөнхийлөгч, Дээд зөвлөлийг хэвлэлээр хэрхэн дэмжих вэ? гэдэг талаар дуугарч байгаа юм. Хэрвээ та “Российские вести” сонинг авч харвал тэнд онцгой сайн ерөнхий сайд, гайхалтай мундаг ерөнхийлөгчийн тухай бичсэн байгаа. Харин “Российская вести” сонинд бол хамгийн ухаантай спикер, гарамгай сайн парламент, муу муухай ерөнхийлөгчийн тухай та уншина. Энэ бол бусад ямар ч сонин хэвлэлээс олж харахгүй алагчлал биш үү. Хамгийн инээдэмтэй нь дээрх хоёр сонин хоёулаа төрийн хэвлэл. Аль нь сайн, аль нь мууг би хэлж чадахгүй. Гэхдээ хоёулаа “Правда” сонинтой төстэй. Ганцхан ялгаа нь гэвэл “Правда” сонин жаахан тогтоон барих аястай, бичлэгийн маяг нь жаахан амарлингуй хүнд суртал байсан билээ.

Иймэрхүү нөхцөлд сэтгүүлч хүнийг жинхэнэ ёсоор чөлөөтэй, бие даасан байдалтай болгох, өөрийн цензур биш өөрийн хяналтыг хэрэгжүүлдэг бололцоо нөхцөлийг хангасан харилцааны тийм бүтэц боловсруулах нь туйлын чухал гэж бодогдож байна. Энэ нь сэтгүүлч хүн ядаж мэдээлэл хүлээн авах талаараа төр засгаас хараат бус бие даасан байдалтай байхад хэрэгтэй юм. Манайд

мэдээлэл олж авах боломжийг хангахуйц мэдээллийн тухай хууль, ил тод байдлын тухай хууль үгүйлэгдэж байна. Сэтгүүлчдийн дотор ёс зүйн асуудал хариуцдаг мэргэжлийн ямар ч нэгдэл холбоо байхгүй байна. Өнөөдөр сэтгүүлчид өөрсдийн улс төрийн үзэл бодол, бүх нийтийн санал асуултад яаж хариулах тухайгаа бус бодит хандлага, сэтгүүлчдийн бие даасан байдал, сэтгүүлчийн материалын үнэн зөвийн хэм хэмжээний талаас нь хэрхэн хандах тухай шүүмжлэн хэлэлцэж байх тийм хурал зөвлөлгөөн алга. Бидний байгуулж байгаа капитализм эхний хуримтлалын шатандаа явж байгаа гэж бид ярьж байна. Гэтэл манай сэтгүүл зүй соёлжсон байдал, өөрийн аливаа хяналт байгаа эсэх талаас нь авч үзвэл хөгжлийн дөнгөж эхний шатандаа явж байна.

Миний ойлгож байгаагаар өнөөдөр сэтгүүлчдэд өөрийн цензур бус өөрийн хяналтыг хэрэгжүүлэх боломж олгохуйц чухал элемент болох сэтгүүлчдийн мэдээлэл хүртэх боломж, тэдний хараат бус байдлыг хангасан мэдээллийн тухай, ил тод байдлын тухай хуультай болох нь юуны өмнө хэрэгтэй байна. Өнөөгийн бидний мөрдөж байгаа хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хууль нь янз бүрийн өгүүлэл, нийтлэл хэвлүүлэхдээ гарын үсэг зурах, өөрийн итгэл үнэмшилд харш даалгавар захиалгыг биелүүлэхээс татгалзаж болох талаасаа сэтгүүлчдийн бие даасан байдлыг хангаж байгаа мэт боловч жинхэнэ бие даасан чөлөөт сэтгүүлч байх зохих нөхцөлийг хангаж хараахан чадахгүй байгаа юм. Учир юу гэвэл энэ хуулийн сэтгүүлч гэдэг ойлголтыг тодорхойлсон хоёрдугаар зүйлд сэтгүүлчийн статусыг “улсын бүртгэлтэй нийтийн мэдээллийн хэрэгсэл”-ийн редакцтай тогтоосон харилцаатай нь ямар нэгэн хэмжээгээр холбон үзжээ.

Үүнээс үзвэл хэрвээ та бие даасан сэтгүүлч бөгөөд танд аль ч сонины редакц таашаагддаггүй бол та тусгай статус эдлэхгүй, мэдээ мэдээлэл аль нь ч танд ирэх ёсгүй байх нь. Ингэхлээр та зөвхөн л сэтгүүлчдийн холбооны гишүүн хүн. Хэрвээ та сэтгүүлчийн бүх байгууллагатай эв түнжингүй бол таныг, магадгүй, сэтгүүлчдийн холбооны гишүүн гэдгийг л хүлээн зөвшөөрөхөөс бус энэхүү тодорхойлолтоор чинь таныг сэтгүүлч хүн гэж хэн ч нэрлэхгүй. Энэ утгаараа манай хуульд сэтгүүлчдийн үйл ажиллагааг зөвшөөрөх эрхийн бичиг (лиценз) олгох зарчим (сэтгүүлч байхын тулд тусгай зөвшөөрөл авдаг журамтай улс орон бий. Жишээлбэл, Италид мэргэжлийн сэтгүүлчдийн жагсаалтад бүртгэгдсэн байх шаардлагатай. Тэгвэл та ажил хийсэн, хийгээгүй мэргэжлийн сэтгүүлч байж чадна) орхигджээ. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн аль нэгэн редакцтай холбоотой хүнийг л сэтгүүлч гэж үзэж байгаа үед энэхүү эрхийн зөвшөөрөл өөр байдлаар хэрэгждэг байна.

Гол утгаараа энэ нь урьдын ёс журмын үргэлжлэл юм. ЗХУКН гэж байхад таалалд нийцэхгүй хүмүүсийг сэтгүүлчдийн холбоонд элсүүлэхээс зайлсхийх үүднээс зөвхөн редакцид ажилладаг хүн л сэтгүүлчдийн холбооны гишүүн байж болно гэж дүрмэндээ заасан байлаа. Харин редакцийг ЗХУКН-ын Төв

Хороогоор зөвшөөрдөг байсан бөгөөд энэ нь хэрэг дээрээ орон тооны ажилтануудыг цагдан хянаж байх боломж олгодог байлаа.

Хэвлэл төрийн нөлөөллөөс дээд зэргээр чөлөөлөгдөх ёстой. Сэтгүүл зүйн талаас нь авч үзвэл улсын радио, телевизийн бүтэц байх нь зохисгүй. Төр засгийн харьяаллын ийм бүтэц бүхий улс орон цөөн байдаг нь тохиолдлын юм биш. Европод ийм улс бараг байхгүй. Хуучин социалист орнуудад ч гэсэн ялгаагүй. Албанид байсан, одоо бол үгүй. Англи, Франц, АНУ-д төрөөс санхүүждэг радио, телевизийн компани байдаг ч гэсэн тэр нь Засгийн газарт шууд харьяалагддаггүй, олон нийтийн зөвлөлүүдийн хяналтанд ажилладаг аж.

Манай төрийг цаашид ардчилах үүднээс хэвлэл болон хамгийн холын тусгалтай зэвсэг, харин сэтгүүлчид түүний гарын туслагч нар байх гэсэн номлолоос татгалзах ёстой. Гэтэл манай удирдлага Ерөнхийлөгч, Засгийн газар, Дээд зөвлөл сэтгүүлчдийг өөрсдийн гарын туслагч нар гэж өнөөг хүртэл үзсээр байгаа нь тэднийг биеэ худалддаг эрчүүлээс ялгаагүй байдалд тавьж байна. Сэтгүүлчдийг зарц шиг үзэж байна. Гэхдээ өнөөдөр орчин цагийн нөхцөл байдал өөрчлөгдөж, мэдээлэл XIX зуун, бүр XX зууны эхэн үеийнхээс илүү чухал үүрэгтэй болж, шуурхай, бодит, тал бүрийн мэдээлэлгүйгээр улс нийгэм хөгжих боломжгүй боллоо. Ийм ч учраас сэтгүүлчийн эрх ёолөө, бие даасан байдал өнөөдөр онцгой чухал болж, өөрийн цензур бидний мэргэжлийн ирээдүй, оюутнуудын хэтийн төлөвийн асуудал болон тавигдаж байна. Өөрөөр хэлбэл тэд хуучин шигээ ташуурын дор ажиллаж байх уу, эсхүл зөвхөн хууль ёс, өөрийн хяналтад тулгуурласан жинхэнэ бие даасан хараат бус сэтгүүлчид болох уу гэсэн асуудал тавигдаж байна. Өнөөдөр хэвлэлийн эрх чөлөөний ашиг сонирхлын үүднээс хэн нэгнийг ихээхэн эрх дураараа хэлмэгдүүлж ирсэн казахуудын ташуурын амт, сэтгүүлчдийг нударгын хүчээр дарж байсан Азербайжаны дотоод яамны сайдын үйлдлүүд шиг тээг саад бидний замд хөндөгдөж байна. Эдгээр том, бага саад бэрхшээлийг анхааралдаа авбал гаднын бусдад үл анзаарагдам сэтгүүлчдийн маань нулимс, хөх няц, булдруу болсон нүүр царай биднийг зэмлэнгүй харж, сэтгүүлч хүний жинхэнэ эрх чөлөө, хараат бус байдал, өөрийнцензурээс зайлсхийх боломжийг хамгаалан тэмцэхийг биднээс уриалан дуудаж байгаа шүү гэдгийг хэлүүштэй.

Харамсалтай нь өнөөдөр тийм боломж хараахан алга. Манай сэтгүүл зүй өргөн эрх чөлөөтэй, тун ч олон талтай гэх боловч бас ч хангалттай эрх чөлөө эдэлж чадахгүй байна. Заримдаа улс орондоо юу болоод байгааг олж мэдэхийн тулд хүлээн авагчаа залгаж, урьдын ярьдгаар “эсэргүү” станцын нэвтрүүлгийг сонсон манай ерөнхийлөгч жинхэнэдээ юу хэлчихэв гэдгийг олж мэдэх шаардлага гардгийг хэлэх юун. (Г. Бадамхандын орчуулгаар нийтлэв.)